

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020.01.06

Улаанбаатар хот

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Авлигатай тэмцэх газар Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, 2019 онд дэвшүүлсэн зорилтыг ханган биелүүлэх чиглэлээр дараахь ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан “Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”-ын талаарх мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг боловсруулж, эмхэтгэн УИХ-ын Тамгын газарт, АТГ-ын даргын 2018 оны А/45 дугаар тушаалаар ХАСХОМ-ийн тайлангийн маягтыг шинэчлэн баталсны дагуу дээрх тайланг болон гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэргийн статистик мэдээг боловсруулан Үндэсний статистикийн хороонд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллав.

Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцийн хэрэгжилтийг хянах 2 дугаар мөчлөгийн хүрээнд тус Конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийг тайлагнах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байгаа бөгөөд тайланг бэлтгэн 2019 оны 8 дугаар сард НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанд хүргүүлсэн. Тус улсын конвенцийн хэрэгжилтийг үнэлэхээр сонгогдсон Буркина Фасо, Сингапур улс, НҮБ-ын мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны нарийн бичгийн газрын төлөөлөгчидтэй 12 дугаар сард цахим хурал хийж, 2020 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, байгууллагын нэр бүхий албан хаагчдыг албан ёсны шинжээчээр бүртгүүлээд байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль”, “Зөвшөөрлийн тухай хууль”, “Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагын тухай хууль”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн төслийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэр бүхий албан хаагчид ажиллав.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн төслийг боловсруулах хүрээнд Хууль тогтоомжинй тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зэрэг үнэлгээ, судалгааны ажлыг хийж байна.

Авлигын эсрэг өдрийг олон улсын өдрийг тохиолдуулан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг иргэд, олон нийт, төрийн бус байгууллага, хувийн хэвшилд, төрийн байгууллагуудад гэсэн зорилтот чиглэлээр зохион байгуулав. Энэ хүрээнд “Шударга байдал ба олон нийтийн итгэл” хуулийн байгууллагуудын нэгдсэн зөвлөгөөн, “Авлигын эсрэг чуулган 2019: Цахим шийдэл” сэдэвт чуулга, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 14 их, дээд сургуулийн оюутнууд “Үнэт зүйлсийн боловсрол” сэдвээр лекцийн үйл ажиллагаа, Азийн сан, Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлтэй хамтран 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Албан тушаалтны хөрөнгө орлогод иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягтыг боловсронгуй болгох нь” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг холбогдох бусад арга хэмжээг зохион байгууллаа.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасныг баримтлан байгууллагын мэдүүлэг гаргавал зохих 122 албан хаагчийн 2018 оны ХАСХОМ-ын баталгааны маягтын эх хувийг холбогдох тайлан, бүртгэл, нэрсийн жагсаалтын хамт УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд, “2019 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа болон албан тушаалтнуудын 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчилсэн

бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хороонд, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт заасныг үндэслэн “Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдэлт, явц байдлын талаар”, мөрдөн шалгах ажиллагаа явуулсан авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх танилцуулах тойм мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд явуулсан улсын үзлэгт бэлтгэх ажлыг зохих журмын дагуу хийж хамрагдснаар 95.0 /А/ үнэлгээтэй үнэлэгдэв. Үндэсний аудитын газраас байгууллагын 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн ээлжит аудитын хяналт шалгалтад хамрагдаж, аудитын байгууллагаас “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (*Organisation for Economic Co-operation and Development, OECD*), Дэлхийн банк болон НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хулгайлагдсан хөрөнгө буцаах санаачилга (StAR) болон бусад гадаад улс орны ижил чиг үүрэг бүхий болон бусад байгууллагуудтай харилцан мэдээ, мэдээлэл туршлага солилцох, албан хаагчдыг сурган дадлагажуулах, чадавхижуулах зэрэг чиглэлээр байнгын харилцаа холбоотой байж, хамтран ажиллалаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Зүүн Европ, төв Азийн Авлигын эсрэг сүлжээнээс Монгол Улсын авлигатай тэмцэх тогтолцоо, эрхзүйн орчинд хийсэн 4 дэх удаагийн үнэлгээний тайланг бэлтгэн хүргүүлж, 2019 оны 3 дугаар сард Парис хотод зохион байгуулагдсан тус сүлжээний Бүгд хурлын үеэр Сангийн яам, Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөгчдийн хамт тайланг хамгаалсан. 7 дугаар сард тус үнэлгээний багийн шинжээчид тайлангийн үр дүнг Улаанбаатар хотод танилцуулсан болно.

2018 онд Индонези улсын Бали хотноо зохион байгуулагдсан Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээний Удирдах зөвлөлийн уулзалт, Бүгд хурлаас Монгол Улс удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдож, сүлжээний Бүгд хурал болон Удирдах зөвлөлийг Улаанбаатар хотноо зохион байгуулах эрхийг авч, 2019 онд даргалагч улсаар томилогдов. 2019 оны 9 дүгээр сарын 23-27-ны өдрүүдэд Ази, номхон далайн орнуудын хөрөнгө буцаах байгууллагууд хоорондын сүлжээ (ARIN-AP)-ний Удирдах зөвлөлийн хурал, Бүгд хурал болон Австрали Улсын Дотоод хэргийн яамтай хамтран Олон улсын сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулав. Тус арга хэмжээнүүдэд гадаадын гишүүн 24 улсын, 5 олон улсын байгууллагын 70, дотоодын 7 хууль сахиулах байгууллагын 56 төлөөлөгч буюу нийт 126 хүн оролцов.

Гадаад улсын авлигатай тэмцэх байгууллагатай тогтоосон хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлигын эсрэг газрын дарга тэргүүтэй төлөөлөгчдийн албан ёсны айлчлал 2019 оны 07 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд, БНСУ-ын Авлигын эсрэг, иргэний эрхийн хорооны төлөөлөгчдийн 2019 оны 5 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд хийсэн айлчлал, БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны төлөөлөгчдийн 6 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд тус байгууллагад хийсэн айлчлалыг зохион байгуулж, харилцан туршлага солилцов.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конг мужийн Авлигатай тэмцэх бие даасан хороо байгуулагдсаны 45 жилийн ойн арга хэмжээ, БНКаУ-ын Авлигын эсрэг агентлагаас Олон улсын авлигын эсрэг өдрийг тохиолдуулан 2019 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Нур-Султан хотод зохион байгуулсан арга хэмжээнд нэр бүхий албан хаагчид болон Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга, гишүүд оролцлоо.

Олон улсын байгууллагаас Монгол Улсад зохион байгуулсан сургалтад 90 албан хаагч, гадаад улс оронд зохион байгуулагдсан сургалтад 19 албан хаагчийг суралцуулсан байна.

Дэлхийн банкны Хулгайлагдсан хөрөнгө буцаах StAR санаачилгатай хамтран 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны дунд шатны сургалт”-ыг зохион байгуулсан. Тус сургалтад Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын Ерөнхий газар,

Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголбанк болон байгууллагын эрх бүхий албан хаагчид хамрагдан суралцав. Мөн дээрх санаачлагатай хамтран 2019 оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, ЦЕГ хамтран зохион байгуулсан “Цахим мөнгөн тэмдэгийг ашиглан гэмт хэрэг үйлдэх явдалтай тэмцэх нь” сэдэвт сургалтад албан хаагчдыг хамруулав.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжүүлэх “Монгол улсын Засгийн газарт олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Азийн хөгжлийн банк хамтран 2018 оны 12 дугаар сараас 2 жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Монгол Улс: Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх” төслийн эхлүүлээд байна. Төслийн уялдуулан зохицуулах хэрэгжүүлэгч байгууллагаар Авлигатай тэмцэх газар сонгогдсон бөгөөд төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай бусад чиглэлээр хамтран ажиллаж байна.

Хоёр. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр:

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн 2018 оны тайланг боловсруулах талаар хэрэгжүүлэгч байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, тайланг хүлээн авч, хяналт үнэлгээг хийлээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2017 онд 144, 2018 онд 202 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдснаас 2018 онд 24 арга хэмжээ хэрэгжээгүй, 178 арга хэмжээ зохих хэмжээнд хэрэгжиж, гүйцэтгэл 35,34 хувиар үнэлэгдэв. Ийнхүү хэрэгжилт хангалтгүй байгаа байдалд дүгнэлт хийж, үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар УИХ-ын Тамгын газар, УИХ-аас томилогддог байгууллагуудын удирдлага, УДШ, ШЕЗ, УЕПГ, бүх яам, агентлаг, Нийслэлийн болон 21 аймгийн Засаг дарга, төрийн бус байгууллагууд зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагад зөвлөмж, чиглэл өгөв.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр Азийн сантай хамтран ажиллах төлөвлөгөөг батлаад байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хангах биелүүлэх хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтны хүнд сурталтай үйлчилгээ, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа явуулах зорилго бүхий “Иргэний хяналтын төв”-ийг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Дүнжингарав, Драгон, Мишээл экспо, 6 буудал дахь Оргил худалдааны төв дэх Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд нээв.

Тус төвийн үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгож, тус төвд үүрэг гүйцэтгэх мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, тайлан мэдээг хүлээн авч боловсруулалт хийх, мөн иргэд олон нийтээс мэдээлэл, өргөдөл, гомдол хүлээн авах, тэдэнд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд тандалт хийх, танилцуулга, мэдээлэл хийх зэрэг багц ажлуудыг тухай бүрт гүйцэтгэлээ.

Төрийн эрх бүхий багууллагатай хамтран авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж, хүнд суртлаас ангид байлгах шаардлагаар хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

-Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, төрийн бус зарим байгууллага, Иргэний хяналтын зөвлөлийн гишүүдийн төлөөллийг оролцуулан 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр “Жолоодох эрхийн үнэмлэх олгох, нөхөн олгох, үйл ажиллагааг цахимжуулах, ил тод болгох нь: асуудал ба шийдэл” сэдэвт;

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран “Гадаадаас ажиллах хүчин, мэргэжилтэн авах зөвшөөрлийг цахим болгох нь” сэдэвт;

-Зам, тээврийн хөгжлийн яам, Автотээврийн үндэсний төв салбарын иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран “Улс хоорондын байнгын ачаа тээвэр эрхлэх “С” зөвшөөрөл олгох үйл ажиллагаан дахь хүндрэл бэрхшээл, авлига гарах нөхцөлийг бууруулах нь” сэдэвт;

-Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Дүүргийн үйлдвэр үйлчилгээний хэлтэс, дүүргийн Онцгой байдлын газар болон аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан “Нийтийн хоолны үйлчилгээн дэх эрсдэлд суурилсан мэргэжлийн хяналт шалгалт ба аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх” сэдэвт;

-Үндэсний аудитын газартай хамтран аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын нэгжийн албан хаагчид, холбогдох яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагуудыг оролцуулан “Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга зам” сэдэвт;

-Барилга, хот байгуулалтын яамтай хамтран Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан салбарын яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагууд, барилгын салбарын ТББ-ын төлөөллүүд, барилгын компанийн удирдлагуудыг оролцуулан “Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл” сэдэвт;

-“Аудитын байгууллагын зарим чиг үүргийг аудитын бусад байгууллагаар гүйцэтгүүлэх хэрэгцээ, шаардлага” сэдэвт,

-“Мэдээлэл өгч байгаа иргэн, сэтгүүлчийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх”, “мэдээлэл өгч байгаа иргэнийг урамшуулах тогтолцоо бүрдүүлэх” ажил арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор “Мэдээлэгч (Шүгэл үлээгч)-ийг хамгаалах бодлого, арга зам” сэдэвт;

-АТҮХ-ийн 9-р зорилтын хүрээнд “Транспаренси интернешнл Монгол”, “Шилэн нам” авлигын эсрэг төрийн бус байгууллагуудын түншлэл зэрэг төрийн бус байгууллагуудтай улс төрийн намын болон сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилтийн ил тод байдлыг сайжруулах, хяналт хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх асуудлаар “Улс төрийн намын тухай хууль: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт;

-Хөтөлбөрийн 4.1.10 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд “Жаргалант хангай” ТББ-аас боловсруулсан “Шударга ёсны үзэл санаа төлөвшүүлэх, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн туршилтын хичээлийн хэлэлцүүлэг;

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан “Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй хамтран хууль сахиулах байгууллагын албан хаагчдад зориулан “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нь” сэдэвт сургалт, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлтэй хамтран эрэн сурвалжлах сэтгүүл зүйн 2 удаагийн сургалт (2019.04.08, 26)-ыг тус тус зохион байгуулав.

Хөтөлбөрийн 4.1.1.1 дэх хэсэгт заасан “төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх” ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.6-д заасныг үндэслэн нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг хянах явцад албан тушаалын тодорхойлолтод заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, тус тодорхойлолтын тогтвортой байдлыг хангах, нийтлэг загварын дагуу боловсруулах асуудлаар Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

Хөтөлбөрийн 4.1.10.2 дахь хэсэгт заасан “боловсролын байгууллага болон гэр бүлээр дамжуулан авлигыг үл тэвчих, шударга иргэнийг төлөвшүүлэх зорилгоор олон талт арга хэмжээ зохион байгуулах, авлигын эсрэг боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр, стандартад тусгах” заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын цөм хөтөлбөрийн хичээлд тусгах дээр дурьдсан сургалтын цагийн багтаамжийн судалгааг хийж байна.

АТҮХ-ийн 4.1.1.10-д заасан Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх чиглэлээр Засгийн газрын хэрэг эрхлэх газартай хамтран төрийн яам агентлаг, нутгийн захиргааны 65 байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдын оролцуулан “Төрийн байгууллагуудын өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажилтнуудын форум”-ыг тус тус зохион байгуулав.

Гурав. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён
гэгээрүүлэх ажлын талаар:

3.1 Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх хэсэгт заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих хяналт тавих” чиг үүргийн хүрээнд-Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд татан оролцуулах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх зорилготой АТГ-ын ажлын хэсэг 21 аймагт ажиллав.

Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд татан оролцуулах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах, эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор “Танай хороонд” иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийг Сонгинохайрхан дүүргийн 6 болон Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 2019 оны 10 дугаар сарын 04-ны өдөр зохион байгууллаа. Нийслэлийн хоёр хороонд зэрэг зохион байгуулсан арга хэмжээнд нийтдээ 170 гаруй иргэн биечлэн оролцсон.

Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг шинэ стандартаар хэвлэж, автомашинд байршуулах ажлыг хийж эхэлсэнтэй холбогдуулан тус ажлын шаардлага, эрх зүйн зохицуулалт, дүрэм, журам, судалгааны материал болон холбогдох бусад мэдээлэл, баримт материалыг хянах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яаманд, Монгол Улсын Засгийн газрын “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоол, төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэхээр хөтөлбөрт тусгагдсан зорилтыг ханган биелүүлж байгаа байдлыг хянах зорилгоор ЦЕГ-ын харьяа Бүртгэл, хяналтын төв болон Гадаадын иргэн, харьяатын газарт тус тус ажиллав.

Түүнчлэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.2.4-т заасан “эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох” зорилтыг ханган биелүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Чингэлтэй дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Өргөө амаржих газар, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Шастины нэрэмжит улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Гэмтэл согогийн үндэсний төв зэрэг 6 эмнэлэг, Зам, тээврийн салбарт, түүний дотор Автотээврийн үндэсний төв, Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захиргааны газар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Боловсролын зээлийн сан, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр цэцэрлэгт тус тус ажиллалаа.

Ийнхүү ажиллахдаа авлига, ашиг сонирхлын эрсдлийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж, хууль тогтоомж зөрчсөн, төрийн үйлчилгээг ил тод нээлттэй, хүндрэлгүй явагдах нөхцлийг дордуулсан буюу илүү шат дамжлага бий болгосон, албан тушаалтан болон бусад этгээдэд давуу, ашигтай байдал бий болгож байгаа нөхцөл байдлуудыг тогтоон зарим зөрчлийг газар дээр нь арилгуулах, мөн тухайн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаар санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, шийдвэрлүүлэхээр шилжүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт хийх, мэдээ, мэдээлэл өгөх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэв.

Энэ хүрээнд хяналт шалгалтын үр дүнг танилцуулах, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулахад тулгамдаж байгаа асуудал, хүндрэл бэрхшээл, иргэд, олон нийтэд учруулж байгаа чирэгдлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлийн эрсдлийг бууруулах, түүнээс ангид байх нөхцлийг бүрдүүлэх асуудлаар албаны эрх бүхий албан хаагчид, харилцагчид, төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хангаж хэлэлцүүлгүүдийг шат дараатай зохион байгуулж, эрх бүхий багууллага, албан тушаалтнуудад зөвлөмж, шаардлага хүргүүлээд байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан “Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

сэргийлэх асуудлаар нийтийн албан тушаалтан, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалтыг шинэлэг арга хэлбэрээр үе шаттай зохион явуулах /гадагш/.” ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг явуулав. Үүнд,

Их, дээд сургуулиудын “Хууль зүйн клиник сургалтын төв” болон оюутны холбоо, оюутны хөгжлийг дэмжих клубүүдтэй хамтран ёс зүйг эрхэмлэх, зөв хандлага, дадал эзэмшүүлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааг сурталчилж, авлигын эсрэг залуучуудын байр суурь, нийгэмд хандах хандлагыг судлах зорилготой уулзалт, өдөрлөгийг Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн тэнхимтэй хамтран 2019 оны 04 дүгээр сарын 26, 29-ны өдөр зохион байгуулсан.

World Learning байгууллагын 2016 оноос хойш хэрэгжүүлж байгаа Ардчиллыг бэхжүүлэх залуу манлайлагчид (LEAD) хөтөлбөрийн Авлигатай тэмцэх, ил тод байдлыг сайжруулах багийн “Сайн сургууль” төслийн багийнхантай уулзаж, хамтран Нийслэлийн Улсын 23, 84 дүгээр сургууль, Дундговь аймгийн 1 дүгээр сургууль дээр авлига, ил тод байдлын тухай ойлголт, хандлагын талаар хэлэлцүүлэг, сургалт, уралдааныг сургуулийн захиргаа, багш, сурагчид, эцэг эхийг хамруулан зохион байгуулсан.

АТГ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамтай хамтран боловсролын салбарт зохион байгуулах авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Сонгинохайрхан дүүргийн 26 сургуулийн захирал, 48 цэцэрлэгийн эрхлэгч, нийт 74 албан тушаалтанд, Хан-Уул дүүргийн 18 сургуулийн захирал, 29 цэцэрлэгийн эрхлэгч, нийт 47 албан тушаалтанд “Зөрчлийн тухай хууль ба боловсролын салбар”, “Ашиг сонирхлын зөрчил ба албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт”, “Авлигаас ангид байх нь”, “Хөгжлийн тухай”, “Авлигатай тэмцэх нь: багш нарын манлайлал” гэсэн сэдвүүдээр сургалт зохион байгуулав.

Шударга ёс, ёс зүй, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор “Утаа”, “Авлигын хор хөнөөл”, “Жолооны багш”, “Авлига найз нөхөрлөлийн үерхлийг зогсоохгүй” зэрэг видео шторкыг хийгээд байна. Түүнчлэн Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төрийн байгууллагын хүнд суртал, хилийн боомт дахь одоогийн бодит нөхцөл байдлын талаар болон, төрийн байгууллагад бүртгэлтэй тээврийн хэрэгслээр дараалалгүй хил нэвтэрч, ачаа бараа, хүн тээвэрлэдэг байсан нөхцөл байдлыг Авлигатай тэмцэх газраас шалган тогтоож, зөвлөмж өгөн, таслан зогсоосон үйлдлийг харуулсан “Тоомжиргүй иргэн, толгойгүй төр” сэдэвт шторкыг боловсруулж нийтийн сүлжээнд байршууллаа. Иргэний хяналтын төвийн 4 цэгийн үйлчилгээг сурталчилсан богино хэмжээний шторк, Туулайхүүгийн адал явдал зохиолын баатраар зохиомжилсон хүүхэд зориулсан “Шударга хөдөлмөр илүү амттай”, “Бүгдээрээ хэрэглэдэг юмын ганцаараа хэрэглэж болохгүй”, “Жижиг алдаанаас том гэмшил” сэдэвт 3 төрлийн 3D animation зэргийг хийж, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөөнд байрлах, зар сурталчилгаа, мэдээлэл байршуулах, түгээх зориулалт бүхий LED дэлгэцэнд байршуулж 08:00-24:00 цагийн хооронд өдрийн 70-аас багагүй удаагийн давталтаар олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан.

Авлигын эсрэг сурталчилгаа хийж, түгээх ажлын хүрээнд олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын нийгэмд учруулж буй хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах болон Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 18001969 болон 110 утасны дугаарыг иргэдэд сурталчилах зорилготой номын хавчуурга, сурталчилгааны материал, “Иргэд, олон нийтэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан гарын авлага”, авлигын эсрэг 12 ишлэл афоризм бүхий зурагт хуудсыг боловсруулж олны хүртээл болгов.

“Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ хамтран “Хоёр хотын цадиг: Нээлттэй мэдээллээр дамжуулан ил тод байдлыг нэмэгдүүлж, авлигыг бууруулах нь” сэдэвт үзэсгэлэнг зохион байгууллаа.

Авлигын эсрэг сурталчилгаа хийж, түгээх ажлын хүрээнд олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, авлигын нийгэмд учруулж буй хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах болон Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хүлээн авах 18001969 утсыг сурталчлах зорилгоор дараахь 30,000 хэвлэмэл бүтээгдэхүүн, “Иргэд, олон нийтэд зориулсан авлигын эсрэг хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан гарын авлага”, авлигын эсрэг 12 ишлэл афоризм зурагт хуудас, гомдол, мэдээлэл хүлээн авах

110 утасны дугаарыг иргэдэд сурталчилах зорилготой номын хавчуурга, сурталчилгааны материалыг боловсруулан хэвлүүлж, олны хүртээл болголоо.

Авлигын гэмт хэргийн эсрэг олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, авлигын гэмт хэргийг мэдээлэх 110 дугаарыг олон нийтэд таниулах, авлигын гэмт хэргийн хяналтыг нэмэгдүүлэх зорилго бүхий 4 төрлийн видео рекламьг бүтээж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулав.

Үүрэн телефоны оператор Мобиком, Юнител, Жимобайл, Скайтел компанитай хамтран 110 тусгай дугаарын талаарх мэдээллийг тус операторын харилцагч нарт мессеж хэлбэрээр сурталчлав.

Иргэний хяналтын төвийн 4 цэгийн үйлчилгээг сурталчилсан богино хэмжээний шторк, Туулайхүүгийн адал явдал зохиолын баатраар зохиомжилсон хүүхэд зориулсан “Шударга хөдөлмөр илүү амттай”, “Бүгдээрээ хэрэглэдэг юмын ганцаараа хэрэглэж болохгүй”, “Жижиг алдаанаас том гэмшил” сэдэвт 3 төрлийн 3D animation, 110 утасны видео шторк зэргийг нийтийн мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээ, телевиз, радио болон Улаанбаатар хотод байрлах зарлалын самбарууд болон иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх бүхий л сувгийг ашиглан сурталчлах, мэдээлэх ажлыг зохион байгууллаа.

Их, дээд сургууль, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн номын сангуудад иргэдэд зориулсан авлигын эсрэг номын булан байгуулах ажлыг эхлүүлж, МУИС-ын болон Улаанбаатар хотын номын санд байгуулсан номын буланг нээв.

3.2 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.2 дэх хэсэгт заасан “авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад оруулах” чиг үүргийг хангах хүрээнд “Нийслэлийн Газрын албаны албан хаагчийн ёс зүйн дотоод дүрэм”-ийн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн албан хаагчдын ёс зүйн дүрмийн, Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооноос ирүүлсэн “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”, Эм зүйч, эм найруулагчийн ёс зүйн хэм, хэмжээ, эрх, үүрэг” гэх актыг нэгтгэсэн “Эмнэлгийн ажилтны ёс зүйн дүрэм”-ийн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ирүүлсэн “Мэргэжлийн хяналтын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн төсөл, Гадаад харилцааны сайдын 2018 оны А/54 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Виз мэдүүлгийн төвийн үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага, зохицуулалтын тухай” тушаалыг хянан хянаж, авлигын эрсдэлийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, бусад хууль тогтоомжид нийцүүлэх зэрэг саналыг тусгуулахаар хүргүүлэв.

Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны А/183 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг хянах заавар”-ын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 116 дугаар тогтоолоор баталсан “Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай”, 2014 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”, Булган аймгийн Баяннуур сумын Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын холбогдох заалт, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журам, 2018 оны 29 дүгээр тогтоолуудаар батлагдсан журам, Хишиг-Өндөр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны “Журам батлах тухай” 10 дугаар тогтоол, 2017 оны “Жишиг үнэ тогтоох тухай” 11 дүгээр тогтоол, дүрэм, журмыг хянан үзэж бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгох, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт холбогдох хууль тогтоомжийг зөрчин баталсан 8 дүрэм, журмыг хүчингүй болгох, Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 10 дүгээр сарын 10-ны өдрийн “Норматив батлах тухай” 5 дугаар тушаалыг хянаж согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоо, төрлийн талаарх нормативыг тогтоохтой холбоотой зөрчил, дутагдал, хүнд суртал чирэгдлийг арилгах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар тодорхой санал, зөвлөмж боловсруулж тус тус хүргүүлэв.

3.3 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь хэсэгт заасан “Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх” чиг үүргийн хүрээнд дараахь ажил, арга хэмжээг зохион байгуулав.

Нийт 21 аймаг, нийслэлийн 74 байгууллагын нийт 24378 албан хаагчид сургалт зохион байгуулав.

2019 оны эхний хагас жилд нийтийн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хандлагыг төлөвшүүлэх нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 64 удаагийн сургалтад 6730 нийтийн албан тушаалтныг хамруулахаар төлөвлөснөөс 4947 албан тушаалтныг хамруулж, гүйцэтгэл 73.5 хувьтай байлаа.

Сургалтад хамрагдах болон хамрагдаж байгаа албан тушаалтны мэдээллийн сан үүсгэх, сургалтыг системтэйгээр зохион байгуулах үндэслэлийг бүрдүүлэх, цаг хугацааг хэмнэх, хиймэл ачаалал, чирэгдэл, давхардал, хийдлийг арилгах, бууруулах шаардлагаар сургалтын бүртгэлийн цахим системийг нэвтрүүлээд байна. Тус системээр дамжуулан Олон нийтийн төвд зохион байгуулагдсан 41 удаагийн сургалтад хамрагдсан 3142 албан тушаалтныг бүртгэлд хамруулсан дүнтэй байна. Тус системийг ашиглах арга, аргачлалд сургах зорилгоор төрийн байгууллагын эрх бүхий 85 албан тушаалтныг сургалтад хамруулан, 72 албан тушаалтанд байгууллагын сургалт хариуцагчийн эрх (админ эрх) олгосон.

Сургалтын хөтөлбөрт тусгагдсан “Авлигын шалтгаан, хор хөнөөл”, “Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөл”, “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам”, “Авлигыг мэдээлэх нь: шүгэл үлээх соёл”, “Ашиг сонирхлын зөрчил, анхаарах асуудал”, “төрийн албаны уламжлал, шинэчлэл ба төрийн албаны ёс зүй, үнэт зүйлс”, “Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас учирсан хохирлыг төлүүлэх эрх зүйн үндэслэл”, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг Удирдлагын академийн багш нар, Нийслэлийн прокурорын газрын болон Авлигатай тэмцэх газрын албан хаагчид хариуцан заав.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэшсэн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр МУИС, МУБИС-ийн эрдэмтэн багш, судлаачдын багтай хамтран “Төрийн албаны ёс зүй”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сургалтын модулийг боловсруулж, туршилт сургалтыг хийв. Мөн дээр дурьдсан сургалтын модульд суурилан гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, нээлтын арга хэмжээг зохион байгуулав.

“Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, шүүх, прокурор, агентлаг, төрийн өмчийн оролцоотой хулийн этгээд, нийслэлийн харьяа байгууллагуудын 276 нийтийн албан тушаалтныг хамруулав.

Дээр дурьдсан танхимын сургалтаас гадна бусад төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулав. Тухайлбал, “Авлигатай тэмцэх нь” сэдэвт сургалтыг Монголын байгаль орчны иргэний зөвлөлд зохион байгуулж 60 гишүүнийг, Багануур дүүргийн Прокурорын газартай хамтран тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын 120 албан хаагчид, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан орон нутгийн байгаль хамгаалагчдын сургалтад хамрагдсан 62 албан хаагчид, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо (UADM), Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо (DPI MONGOLIA), Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Ахмадын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Бизнес инкубатор төв, “Бид чадна эм эн” нэгдэл зэрэг 30 гаруй төрийн бус байгууллагын төлөөлөлд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран Орхон аймаг дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, үйлдвэрийн газрын 160 гаруй албан хаагчдад, Зээлийн батлан даалтын сангийн 40 албан хаагчид тус тус авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуульд заасан хориглолт, хязгаарлалтын талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулав.

Бусад байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу, тухайлбал, Хууль зүйн туслалцааны төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу 62 өмгөөлөгч, Эрчим хүчний хөгжлийн төвийн 96 албан хаагч, ЦЕГ-ын харьяа 21 аймгийн цагдаагийн газрын Тамгын хэлтсийн дарга болон урьдчилан сэргийлэх ажил хариуцсан 42 албан хаагч, Нийслэлийн цагдаагийн газрын 200 албан хаагч, Дотоодын Цэргийн 805 дугаар ангийн 260 албан хаагчид “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр, Монголын уран зургийн галерейн 15 албан хаагч, Гадаадын иргэн, харьяатын газарт шинээр байцаагчаар томилогдсон 20 албан хаагчид “Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа” сэдвээр, Эрүүл мэндийн яамны эрх олгох, тусгай зөвшөөрөл хариуцсан 15 албан хаагчид “Авлигын хор хөнөөл, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр, Улсын нэгдүгээр төв эмнэлгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тус эмнэлгийн 212 албан

хаагчид “Хандив авах, албан бус төлбөр хураамж, давхар ажил эрхлэлттэй холбоотой хориглолт хязгаарлалт” сэдвээр, Авто тээврийн үндэсний төвийн “Удирдах ажилтны зөвлөгөөн”-д “Авлигын эсрэг хууль тогтоомж, авлига түүнээс урьдчилан сэргийлэх арга” сэдвээр 21 аймаг, нийслэлийн авто тээврийн дарга нар болон ахлах ажилтан, нийт 85 албан хаагчид мэдээлэл өгсөн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Дорноговь аймгийн Цагдаагийн газар, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний алба, Улсын бүртгэлийн хэлтэс, Дорноговь аймаг дахь Тагнуулын хэлтэс, Дорноговь аймаг дахь Гадаадын иргэн харьяатын газар, Хууль зүйн туслалцааны төв, Хилийн 0108 дугаар анги, Хилийн 0129 дүгээр анги, Хилийн 0168 дугаар анги, Сумдын Засаг дарга, Сумдын ЗДТГ-ын Хууль зүйн мэргэжилтнүүд зэрэг 280 төрийн албан хаагч оролцсон “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-д оролцож, авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигатай тэмцэх газраас тус аймагт хүргүүлсэн зөвлөмжийн талаар мэдээлэл хийлээ.

3.4 Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь хэсэгт заасан “авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлын талаар зөвлөмж гаргах, байгууллага, иргэний хүсэлтээр түүний үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх” чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэв. Үүнд:

-2018 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Боловсролын салбар дахь авлига, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгээс гаргасан саналыг нэгтгэн 13 зүйл бүхий зөвлөмжийг боловсруулж, тус зөвлөмж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад,

-2019-2020 оны хичээлийн жилд Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойргийг шинэчлэн болон шинээр тогтоох, сургууль, цэцэрлэгт шинээр хүүхэд элсүүлэн суралцуулах үйл ажиллагааг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, ил тод байдлаар зохион байгуулах талаарх санал, зөвлөмжийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн боловсролын газарт;

-Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд төрийн байгууллагын өмчлөлд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ашиглан Замын-Үүд-Эрээний боомтоор дараалалгүйгээр зорчигч, ачаа тээвэрлэж хууль бус ашиг, орлого олж байгаа асуудлыг таслан зогсоох асуудлаар Хилийн 0108 дугаар ангийн захирагчид;

-Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлэх хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдлыг хянах зорилгоор Хан-Уул дүүргийн газрын албанд ажиллаж, тогтоогдсон нөхцөл байдалд дүгнэлт хийн зөрчлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллах талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид;

-Төв аймгийн Боловсролын газрын дарга хандив авсан асуудлыг шалгаж, тогтоогдсон нөхцөл байдал, цаашид анхаарах асуудлын талаарх зөвлөмжийг аймгийн Засаг даргад;

-Гадаадын иргэн, харьяатын газрын Виз, зөвшөөрөл, харьяатын газрын үйл ажиллагаа, мэдээллийн болон төрийн үйлчилгээний ил тод байдалтай танилцаж, хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлох зорилгоор ажиллаж, хууль тогоомж зөрчсөн нөхцөл байдлыг тогтоон зөрчлийг арилгах, авлига, ашиг сонирхлын эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулах талаар тус Газрын даргад;

-Төрийн үйлчилгээг хүнд, суртал чирэгдэлгүй цахим хэлбэрээр үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор амьтан, ургамал түүхий эд, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнийг хилээр нэвтрэх тохиолдолд импортын мэдэгдэл, экспорт, импортын гэрчилгээ олгох үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлж, 8 зүйл бүхий зөвлөмжийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт;

-Эрүүл мэндийн салбарт гарч байгаа авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын гэмт хэргийн эрсдэл, зөрчлийг арилгах, дахин гаргуулахгүй байх чиглэлээр Эрүүл мэндийн сайдад;

-Иргэдийн өргөдөл, гомдол болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр гадаад паспорт олголтын үйл ажиллагаа удааширсан, урт дараалал үүсч иргэдийг чирэгдүүлж байгаа асуудалтай

холбогдуулан Нийслэлийн Улсын бүртгэлийн хэлтэс, төрийн үйлчилгээний нэгдсэн 4 төв болон дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг тандан судалж, УБЕГ-ын даргад;

-MNS 4410-2:2017 стандарт, “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-тай холбоотой хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн сайдад;

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт гадаадаас ажиллах хүчин, мэргэжилтэн авах зөвшөөрөл олгох ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явц байдалтай танилцаж, төрийн үйлчилгээний хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцлийг арилгах чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад;

-Засгийн газрын 2019 оны “Түрээсийн орон сууцны талаар авах арга хэмжээний тухай” 223 дугаар тогтоол, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны “972 айлын орон сууцанд иргэдийг хамруулах тухай” 115 дугаар тогтоолын дагуу Засаг дарга, Нийслэлийн орон сууцны корпорациас зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах арга хэмжээг зохион байгуулж байгаатай авлигын эрсдэл гарахаар урьдчилан сэргийлэх, ил тод нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтээс хяналт тавих боломжийг бий болгох, иргэдийг төөрөгдүүлж, чирэгдүүлэхгүй байх, албан тушаалтнууд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлсэн байна.

Байгууллага, иргэний хүсэлтээр төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь авлигад өртөх боломжийг багасгах талаар заавар, зөвлөгөө өгөх хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/648 дугаар тушаалыг хянаж, “Эрчим хүчний яамнаас зарласан албан тушаалын сонгон шалгаруулалттай холбоотой, 1072 хувьцаатай холбогдуулан брокерийн пүүс хууль бус төлбөр хураамж авч байгаа асуудал, Монгол Улсын их сургуулийн эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох асуудал, Багануур дүүргийн 193, Баянзүрх дүүргийн 255 дугаар цэцэрлэгээс хууль бус хандив шаардсан болон холбогдох бусад асуудлаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хянан шалгаж, тогтоогдсон нөхцөл байдалд дүгнэлт хийн хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцох, цаашид зөрчил гаргахгүй байх, “Эрчим хүчний салбарын төрийн өмчит байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм”-ийн төсөлд “хараат бус байж гадны нөлөөнд автахгүй байх”, “ажилтан нотлогдоогүй мэдээ, мэдээллийн талаар хэвлэл мэдээллийн байгууллага, хувь хүнд мэдээлэхгүй, урьдчилан дүгнэлт хийхгүй байх”, “зөрчлийн шинж байдлыг харгалзан зохих шийдвэрийг гаргана”, “хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэгдсэн мэдээ, мэдээлэл”, ажилтан нь удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгавар, шийдвэрийг бүрэн биелүүлж ажлын үр дүн, биелэлтийг тогтоосон хугацаанд тайлагнадаг байна” гэх зэрэг зүйл, заалтыг нэмж тусгахыг анхааруулж, зөвлөмж, заавар өгч хуулийн хэрэгжилтийг хангуулав.

Дөрөв. Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар

4.1 Судалгааны ажлын талаар:

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 болон 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу Шударга байдлын үнэлгээ 2019 оны судалгааг гэрээний үндсэн дээр хийлгэж, судалгааны тайланг хүлээн авч, дүнг танилцуулах, мэдээлэх ажлыг зохион байгуулав. Шударга байдлын үнэлгээнд 2019 онд 62 яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг хамруулсан. Урьдчилсан тооцооллоор Шударга байдлын үнэлгээ 72.5 гарсан нь 2018 оныхоос 3.8 пунктээр нэмэгдсэн байна. Үнэлгээний дүнгээс харахад төрийн байгууллагаас үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллөөс өгсөн үнэлгээний дүн бусад үнэлгээнээс харьцангуй доогуур үзүүлэлттэй байна.

“Хүүхдийн шударга байдлын түвшин-2019” судалгааг аймаг, нийслэлийн боловсролын газартай хамтран 6576 хүүхдийг хамруулан зохион байгуулж үр дүнгийн тооцооллыг хийж тайланг боловсруулан олон нийтэд танилцуулав. Тус судалгаагаар хүүхдийн шударга байдлын түвшин 3.91 гэсэн дүнтэй гарсан байна.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт хандлагыг тодорхойлох судалгаа”-г гэрээгээр гүйцэтгүүлж, тайланг хүлээн авч, үр дүнг байгууллагын албан хаагчдад танилцуулах ажлыг зохион байгуулав.

2019 оны авлигын эрсдлийн үнэлгээг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Нийслэл Өргөө амаржих газар, Шастины нэрэмжит гуравдугаар төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, МУИС, МУБИС, АШУУИС, Төрийн өмчийн оролцоотой Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ, Авто тээврийн үндэсний төв, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл, МИАТ ТӨХК, Монгол шуудан ТӨХК, Хөдөө аж ахуйн бирж ТӨХК, нийт 15 байгууллагыг хамруулан зохион байгуулсан.

Үнэлгээ хийсэн байгууллагуудаас тайланг ирүүлснийг хянаж, Улсын нэг, хоёрдугаар төв эмнэлэг, Халдвар судлалын үндэсний төв зэрэг төрийн өмчийн эмнэлгүүдэд хийсэн үнэлгээний дүнг 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, МУИС, МУБИС, АШУУИС-д хийсэн үнэлгээний дүнг 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХГ, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ, МИАТ ТӨХК, Монгол шуудан ХК, Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК-д хийсэн үнэлгээний дүнг 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдөр үнэлгээнд хамрагдсан байгууллагууд болон бусад холбогдох эрх бүхий албан тушаалтан, олон нийтэд нээлттэй мэдээлсэн болно.

“Улс төрийн хүрэн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа” болон “Шүүх, хууль хяналтын байгууллагын хүрэн авлигын талаарх төсөөллийн судалгаа”-г “зохих журмын дагуу судалгааны байгууллагуудаар хийлгэв. Судалгаагаар улс төрийн болон хууль хяналтын байгууллагын хүрээний авлигын түвшин өссөн дүнтэй гарсан байна.

“Дээд боловсролын салбар, орчин дахь ёс зүйн тандалт, судалгаа”-г хийлгэж, Судалгааны үр дүнтэй холбогдуулан “Боловсролын салбар дахь ёс зүйн асуудал” хэлэлцүүлгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх хүрээлэн, ДХИС, МУБИС, АШУИС, МУИС болон ШУТИС зэрэг их сургуулийн багш эрдэмтэн, судлаачид, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулав. Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан саналыг тусган холбогдох зөвлөмжийг БСШУСЯ-ны сайдад хүргүүлээд байна.

4.2 Дүн шинжилгээний ажлын талаар:

Авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн сангийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд мэдээллийн сангийн программ хангамж хийх нөхцлийг бүрдүүлэв.

Авто зам барих, засварлах тусгай зөвшөөрөлтэй 495 аж ахуй, нэгжийн хамаарлын судалгаа, Монгол Улс болон олон улсын хэмжээнд цахим төлбөр тооцоо, цаасан мөнгөний хэрэглээний нөхцөл байдлын талаар судалгаа, улс төрийн намын дарга, дэд дарга хөрөнгө, орлогын мээүүлэг мэдүүлдэг эсэх талаарх судалгаа, Авлигатай тэмцэх газрын талаарх олон нийтийн санаа бодлын үнэлгээнд дүн шинжилгээ хийж байна.

Авлигатай тэмцэх газрын талаарх олон нийтийн санаа бодлын үнэлгээнд дүн шинжилгээ хийх хүрээнд Азийн сангийн Авлигын талаарх олон нийтийн тандалт судалгааны 2018 оны тайлан, Дүнжингарав төвөөр үйлчлүүлсэн иргэдийн АТГ-ын үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээ, Транспарэнси интернэшл байгууллагын АТГ-т өгсөн үнэлгээний тайлан, 2015-2018 оны Шударга байдлын үнэлгээний иргэд, төрийн албан хаагчид, шинжээчдийн үнэлгээнээс холбогдох үнэлгээг түүвэрлэн авч боловсруулалт хийж байна.

Төрийн байгууллагын нэг цэгийн үйлчилгээний чанар хүртээмж, үйлчилгээ авч байгаа иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг тодруулахаар 2 төрлийн судалгааны асуулга боловсруулж, нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлж буй 200 иргэнээс асуулга авч, мэдээллийг нэгтгэн тайланг боловсруулж, олон нийтэд үр дүнг танилцуулав.

“Дээд боловсролын салбар дахь ёс зүй” асуудлаар хийх тандалт судалгааны танилцуулга, ажлын удирдамж, судалгааны ажлын төсвийн төслийг баталж, судалгааны ажлын гүйцэтгэчийг сонгох зөвлөх үйлчилгээний зарын дагуу ирүүлсэн баримтад тулгуурлан эцсийн шалгаруулалт хийж байна.

“Шударга ёс” эмхтгэлийн 16 дахь дугаарыг хэвлүүлж, 17 дахь дугаарыг хэвлэлтэд шилжүүлэв.

Тав. Хяналт шалгалт, дүн шинжилгээний
ажлын талаар:

5.1 Мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар:

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 110 байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, нэгдсэн дүн, мэдээг гаргалаа.

ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх хуулийн хугацаанд буюу 2019 оны 02 дугаар сарын 15-ны дотор улсын хэмжээнд нийт 41382 мэдүүлэг гаргагч /цахим хэлбэрээр-3934, хэвлэмэл байдлаар-37447/ мэдүүлгээ гаргаж бүртгүүлэхээс хуулийн хугацаанд 41381 мэдүүлэг гаргагч мэдүүлж, 1 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй. Ийнхүү мэдүүлэг гаргагч албан тушаалтанд зохих журмын дагуу хариуцлага хүлээлгэв.

Хүснэгт 1 ХАСХОМ гаргасан албан тушаалтнуудын тоон үзүүлэлт /сүүлийн 3 жилийн байдлаар/

Үзүүлэлт		2016	2017	2018
Бүрдүүлбэл зохих		39742	40073	41382
Бүрдүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		39739	40067	41381
Үүнээс:	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	1	4	-
	Мэдүүлгээ гаргаж өгөөгүй	2	2	1
Бүрдүүлэлтийн хувь		99.9	99.99	99.99


Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 175 дугаар тогтоолоор Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрыг татан буулгаж, Оюуны өмчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар гэсэн бие даасан агентлаг болгон өөрчлөн зохион байгуулсан, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн 250 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн ерөнхий газар агентлаг байгуулсан, Мал эмнэлгийн үржлийн газрын бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, Мал эмнэлгийн ерөнхий газар болж орон тоог нэмэгдүүлсэн, Хил хамгаалах ерөнхий газрын албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсон, мөн ТӨХК, ТӨҮГ, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд нэмэгдсэн, Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсан, Засгийн газрын 25 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2018 онд мэдүүлгээ шинэчлэн гаргасан мэдүүлэг гаргагчийн тоо өмнөх оноос 1309 нэгжээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2 Нэмэгдсэн мэдүүлэг гаргагчдын талаар:

Нэмэгдсэн мэдүүлэг гаргагчийн тоо	Ангилал, зэрэглэл			
	ТЗ	ТТ	ТҮ	Төрийн болон Орон нутгийн өмчийн оролцоотой компани
1309	309	356	140	504


2018 оны ХАСХОМ-ээ шинэчлэн гаргасан нийт мэдүүлэг гаргагчдын 10749 буюу 26 хувь нь төрийн захиргааны, 12863 буюу 31 хувь нь төрийн тусгай, 7448 буюу 18 хувь нь улс төрийн, 4594 буюу 11.2 хувь нь төрийн үйлчилгээний удирдах, 282 буюу 0.6 хувь нь төрийн өндөр болон Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг, 2549 буюу 6.2 хувь нь төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдах, 2896 буюу 7 хувь нь бусад албан тушаалтнууд байна.

Хүснэгт 3 ХАСХОМ гаргасан албан тушаалтан



Мөн нийт мэдүүлэг гаргагчийн 23175 буюу 56 хувь нь Улаанбаатар хотод, 18206 буюу 44 хувь нь орон нутагт байна. Нийт мэдүүлэг гаргагчдын 16125 буюу 38.9 хувийг ахлах мэргэжилтэн, түүнээс дээш ангиллын удирдах албан тушаалтнууд эзэлж байна. Орон нутгаас Хөвсгөл аймгаас 1188 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлт болж байна.

Хүснэгт 4: ХАСХОМ мэдүүлсэн мэдүүлэг гаргагчийн тоо /аймгаар/



Төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээний дүнгээс үзэхэд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан үндэслэлийн дагуу “хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлт”-ийн талаар мэдүүлсэн 604, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасныг үндэслэн “тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл” гаргасан 53029, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан “ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл” гаргасан 1309 мэдүүлэг гаргагч байна.

Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, 14.3-т заасан үндэслэл болон төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжийг олгох зорилгоор хуваарийн дагуу Төрийн болон нутгийн захиргааны нийт 36794 албан тушаалтны 2018 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xasxom.iaac.mn> цахим хуудсанд нээлттэй байршуулсан.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын ангилал, зэрэглэл”, 275 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл”, 276 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Авлигын эсрэг хууль, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоол

буюу ХАСХОМ гаргах албан тушаалтны хамрах хүрээг оновчтой тогтоох, ХАСХОМ-ийн маягтыг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

5.2 Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг төрийн өндөр болон бусад албан тушаалтнуудын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар:

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-т заасны дагуу Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлэх үүрэгтэй төрийн өндөр болон бусад 293 албан тушаалтнаас албан үүргээ гүйцэтгэж байгаа мэдүүлгээ шинэчлэн гаргаж бүртгүүлвэл зохих 283 албан тушаалтнаас 282 албан тушаалтан бүртгүүлсэн болно. Дээрх албан тушаалтнуудын жагсаалтыг гаргаж, мэдүүлэг гаргагчдад зөвлөмж, чиглэл өгч арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан.

Тайлант хугацаанд төрийн албанд томилогдож, мэдүүлгээ бүртгүүлсэн яамны 2 сайд, 10 агентлагийн дарга, 3 элчин сайд, консул, УИХ-ын дэргэдэх 5 байгууллагын дарга, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дэд дарга, Ерөнхий аудитор, бусад 11, нийт 33 албан тушаалтан байна. Мөн төрийн өндөр 14 албан тушаалтан /Улсын Их Хурлын гишүүн 3, элчин сайд 1, Төрийн нарийн бичгийн дарга 1, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга 1, агентлагийн дарга 2, бусад 6/ нь хөрөнгө, орлогод орсон их их хэмжээний өөрчлөлтийг мэдүүлснийг хуулийн хугацаанд хүлээн авч, хяналт тавин ажиллалаа.


5.3 Сургалт сурталчилгаа, мэдээлэл арга зүйн ажлын талаар:

Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн албан тушаалтны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, гаргаж байгаа нийтлэг зөрчил, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, мэдүүлгийг бүртгэж хадгалах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг мэргэшүүлэх, хяналтыг сайжруулах, удирдах албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр сургалтыг зохион байгуулав.

Энэхүү сургалтад Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн, Нийслэлийн Боловсролын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ашигт малтмал, газрын тосны газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяа газрууд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагууд, Мэргэжлийн хяналтын газар, Батлан хамгаалах яам, Сонгинохайран, Хан-Уул дүүргийн сургууль, Тээврийн прокурорын газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Нийслэлийн дүүргүүдийн эрүүгийн болон иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид, захиргааны албан тушаалтнууд, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар зэрэг төрийн болон нутгийн захиргааны байгууллагын давхардсан тоогоор 9138 мэдүүлэг гаргагч болон эрх бүхий албан тушаалтнуудыг сургалтад хамруулж, мэдлэг, мэдээлэл олгох замаар чадавхижуулах арга хэмжээ авлаа.

Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын 1704 мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ы судалгааг шинэчлэн гаргасан бөгөөд 2019 оны байдлаар шинээр томилогдсон 178 ЭБАТ байгаагаас төрийн захиргааны төв байгууллагын 115, аймаг, орон нутгийн захиргааны байгууллагын 63 байна. Сүүлийн 3 жилийн байдлаар 744 ЭБАТ буюу 43.6 хувь нь өөрчлөгдсөн, үүнээс 308 буюу 33.6 хувь нь нутгийн захиргааны байгууллагад хамаарч байна. Иймд ЭБАТ-уудыг мэргэшүүлэх, чадавхижуулах, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтыг 2019 оны 01 дүгээр сарын 8, 9-ний өдрүүдэд зохион байгуулж, салбар, нэгжийн нийт 364 болон Үндэсний аудитын байгууллагын орон нутгийн 402, 21 аймгийн 545, нийт 1311 ЭБАТ-ыг сургалтад хамруулав.

Хүснэгт 5: Сургалтад оролцогчдын тоон үзүүлэлт
/3 жилээр байдлаар/



Мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд сургалт сурталчилгааг зохих журмын дагуу хийж, хуулийн хугацаа сануулсан сурталчилгааны баннерыг МҮОНРТ, МН-25, ЕТВ, ТВ-8, Эх орон, Ийгл, TV-58 нийт 9 телевизээр, АТГ-ын цахим сайт, www.zaluu.com, www.news.mn, www.ikon www.medee.mn www.newspress.mn сайтуудад баннерыг байршуулсан. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор ашиг сонирхлын зөрчил болон ХАСХОМ, ХАСУМ-ийн хяналт шалгалтаар илэрдэг нийтлэг зөрчил, анхаарах асуудлаар “Харандааны адал явдал” зохиомжит хөдөлгөөнт шторк, 3 төрлийн шторк, зохиомжит промог бэлтгэн олон нийтэд түгээн таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулав.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан нарт зориулсан гарын авлага”-ын шинэчилсэн 7 дахь, загвар жишээ бүхий “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”-ын шинэчилсэн 5 дахь хэвлэлийг хэвлүүлж, холбогдох байгууллага, орон нутаг, мэдүүлэг гаргагч нарт хүргүүлж, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулав.

5.4 Судалгаа, дүн шинжилгээний ажлын талаар:

2018 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хэвлэмэл болон цахимаар гаргасан нийт 41381 мэдүүлэг гаргагчдын байгууллага, салбар болон албан тушаалын ангилал зэрэглэл, суурьшлын байдлаар нь болон аймаг тус бүрээр, мөн удирдах албан тушаалтны талаарх нэгдсэн болон харьцуулсан судалгааг гаргав.

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын тус баримтлан Монгол банкны 242, Санхүүгийн зохицуулах хорооны 65, Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдүүлгээ гаргасан эрүүгийн танхимын 93 шүүгч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт мэдүүлгээ гаргаж бүртгүүлсэн ТӨХК-ийн удирдах 701 буюу нийт 1101 мэдүүлэг гаргагчийн 2017, 2018 оны ХАСХОМ-ийн байдалд хяналт тавьж орлого, хөрөнгийн байдалд харьцуулсан судалгааг хийв.

Цахим систем ашиглан хийсэн, судалгаа дүн шинжилгээний хүрээнд дээрх байгууллагуудын мэдүүлэг гаргагчдаас хамгийн өндөр үнийн дүнтэй болон өндөр үнэлгээтэй орлого, хөрөнгийн байдалд үнэлгээ дүгнэлт өгч, хөрөнгө, орлого нь жилээс жилд өссөн, хувийн ашиг сонирхлын зөрчил бүхий шинжтэй, орлого хөрөнгө нь зөрүүтэй мэдүүлгээ худал мэдүүлсэн байж болзошгүй гэх үндэслэлээр нийт 71 албан тушаалтны ХОМ-ийг нарийвчлан хянан шалгах шаардлагатай байгааг тодорхойлж шалгуулахаар шилжүүлээд байна.

Хуулийн үйлчлэлд хамрагдаж ХАСХОМ-ийг мэдүүлсэн албан тушаалтнуудын “Орлого”-ын талаарх мэдээллийг орлого тус бүрээр нь /7 төрлийн орлого/ түүвэрлэн гаргаж, 2018 онд хамгийн өндөр орлого мэдүүлсэн эхний 30 мэдүүлэг гаргагчийн судалгааг гарган хянан үзэж холбогдох арга хэмжээг авав.

Төрийн байгууллагуудын ажлын уялдаа, ХАСХОМ-ийн үнэн бодит байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцлийг бүрдүүлж, зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Татварын Ерөнхий газар болон Нийгмийн даатгалын Ерөнхий газар, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

Энэ хүрээнд Татварын ерөнхий газар, нийслэл, дүүргийн татварын хэлтэстэй хамтран ажилласнаар Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон Татварын ерөнхий хуулийг зөрчсөн нийт 1.133.194.100 /Нэг тэрбум нэг зуун гучин гурван сая, нэг зуун ерөн дөрвөн мянга, нэг зуун төгрөг/ төгрөгийн зөрчлийг илрүүлж, 3 иргэн, 4 аж ахуйн нэгж байгууллагад 71.043.400 төгрөгийн торгууль ногдуулсан, 1 албан тушаалтныг нийтийн албанаас халах, 2 албан тушаалтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулаад байна.

Нийтийн албан тушаалтнаас Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөн ажиллаж байгаа эсэхийг эрх бүхий төрийн байгууллагатай хамтран хяналт тавин ажиллав. Энэ хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллаж, давхар ажил эрхлэлтийн байдлыг хянаж судалгааг хийснээр хууль зөрчсөн үйлдлийг илрүүлж, 6 албан хаагчид хариуцлага ногдуулах шаардлагыг хүргүүлэв.

Нийтийн албан тушаалтныг албан тушаалд томилохдоо ажлын байрны тодорхойлолтыг баримтлахгүй байх эсхүл хувь иргэнд зориулан боловсруулж, давуу байдал бий болгох зэрэг зөрчил түгээмэл гарч байгаа тул зөрчлийг арилгах чиглэлээр Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллаж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрт бүхий л гүйлгээг бэлэн бусаар хийх хууль санаачлах, мөн Татварын тайланг хүн бүрээс авах тогтолцоо руу шилжих боломж нөхцлийг судлах хүрээнд Монгол Улсын хэмжээнд худалдан авалт, төлбөр тооцоо, гүйлгээг бэлэн бусаар хийх, цахим төлбөр тооцоонд шилжих асуудлыг хуулийн хүрээнд зохицуулахын тулд эхний ээлжинд гадаад орнуудын туршлага, Монгол улсад дахь цахим төлбөр тооцоо хэрэгцээ, шаардлага, тоо баримт, хэрэглэгчийн үзүүлэлт, үнэлгээ, жилд дунджаар цахимаар хийгдэж байгаа гүйлгээ дүн, идэвхи, цалингийн карт, кредит шилжүүлэг, интернетбанк, төлбөрийн карт, гар утаснаас шилжүүлэх болон цахим карт ашиглаж байгаа хэрэглэгчдийг байршил, нутаг дэвсгэр зэрэг үзүүлэлтээр судалгааг хийв.

УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” (АТҮХ)-ийн 4.1.1.6 дахь хэсэгт “нийтийн албаны ...ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх”, 4.1.1.7 дахь хэсэгт “Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгох...”, 4.1.2.5 дахь хэсэгт “төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаарх судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах” үйл ажиллагааг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах гол үйл ажиллагааны нэг байхаар тусгасан тул Авлигын эсрэг хууль, АТҮХ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд авлигын болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг, шүүхийн шийдвэрт судалгаа хийж, түүний үндэслэл, шалтгаан, нөхцөл, авлигын болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой захиргааны хэргийг ялгаатай шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт судалгаа, дүн шинжилгээ хийлгэхээр гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллалаа.


Судалгааны тайланг хүлээн авч, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 05, 20 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох саналыг боловсруулж, судалгааг хийж байна.

5.5 Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт, шалгалтын ажлын талаар:

2019 онд шинээр хүлээн авсан 324, өмнөх оны үлдэгдэл 79, нийт 403 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянан шалгаснаас 381 мэдүүлгийг шалгаж дуусган, 22 албан тушаалтны мэдүүлэг ажиллагаанд байна.

Тайлант хугацаанд шалгасан нийт мэдүүлгийн 316 буюу 78.4 хувийг төлөвлөгөөт хяналт шалгалтаар, 30 буюу 7.4 хувийг иргэний гомдол, мэдээллээр, 57 мэдээллийг бусад хэлтэс, албадаас шилжүүлснийг хянан шалгасан байна.

Хүснэгт 6 Мэдүүлгийн хяналт шалгалтын тоон үзүүлэлт /өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал/



2019 онд хүлээн авсан ХАСХОМ-ийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 153 нэгжээр буюу 89.2 хувиар, шалгаж шийдвэрлэсэн ХАСХОМ 210 нэгжээр буюу 2.2 дахин, 35 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 21 нэгжээр буюу 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 7 ХАСХОМ-ийн хяналт шалгалт

Он	ХАСХОМ					Хариуцлага тооцуулсан байдал
	Өмнөх оны үлдэгдэл	Тайлант хугацаанд хүлээж авсан	Шалгавал зохих	Шалгаж шийдвэрлэсэн	Үлдэгдэл	
2018	34	216	250	171	79 /31,6%/	14
2019	79	324	403	381	22 /5,45%/	35

2019 онд нийт шалгавал зохих ХАСХОМ-ийн 94.5 хувийг шалгаж шийдвэрлэсэн байна.


Хууль зөрчсөн 6 албан тушаалтанд сануулах, 20 албан тушаалтанд албан тушаалын цалин бууруулах, 1 албан тушаалтанд албан тушаал бууруулах, 8 албан тушаалтанд нийтийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсан байна. Мөн хяналт шалгалтаар “үндэслэлгүй хөрөнгөжсөн” байж болзошгүй 30 албан хаагчид холбогдох үйлдэлд мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар холбогдох хэлтэст шилжүүлэн шалгуулж байна.

2019 онд бүх шатны шүүгчид, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнууд зэрэг нийт 381 албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгасан байна.

5.6 Өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар:

2019 онд албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 692, өмнөх оны үлдэгдэл 50, нийт 742 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авснаас тайлант хугацаанд 694-г хянан шийдвэрлэсэн бөгөөд 48 өргөдөл, гомдол, мэдээлэл ажиллагаанд хянагдаж байна. Хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 70 нэгжээр буюу 10.4 хувиар, хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдол 72 нэгжээр буюу 11.5 хувиар, шийдвэрлэлт 1.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8 Хянан шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл



Хүлээж авсан нийт өргөдөл, гомдлын 45.0 хувийг Улаанбаатар хотод оршин суугчдаас, 34.5 хувийг орон нутгаас, 20.5 хувь нь нэр хаяггүй байна.

Шалган шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн агуулгыг үзвэл:

-Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, хэтрүүлсэн талаар 111 буюу 15.9 хувийг,

-Албан тушаалын байдлаа ашиглан өөртөө болон бусдад давуу байдал олгосон талаар 116 буюу 15.6 хувийг,

-Албан үүргээ гүйцэтгэхдээ ашиг сонирхлын зөрчил гаргаж, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн талаар 98 буюу 14.2 хувийг,

-Ашиг сонирхлын зөрчилтэй хууль бус томилгоо, шийдвэр, хууль бус үйлдэл гаргасан талаар 110 буюу 14.8 хувийг,

-Албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгуулах талаар 30 буюу 0.4 хувийг,

-Хүнд суртал, ёс зүйн зөрчил шалгуулах талаар 55 буюу 7.4 хувийг

-Худалдан авах ажиллагаа болон тендер сонгон шалгаруулалтын талаар шалгуулах 36 буюу 4.8 хувийг,

- Бусад 186 буюу 26.9 хувийг тус тус эзэлж байна.

Гомдол, мэдээлэлд дурьдсан нөхцөл байдлыг хянан шалгаж, хууль зөрчсөн 37 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулан, ашиг сонирхлын зөрчил үүсэх эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцлийг үүсгэж байгаа талаар тухай бүр мэдэгдэж, анхааруулав. Төрийн бусад байгууллагад харъяаллын дагуу 139, авлигын гэмт хэргийн шинжтэй гэж үзэж 98 гомдол мэдээллийг шалгуулахаар шилжүүлсэн байна.

5.7 Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан талаар:

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 8682 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 8627 мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 55 мэдүүлэг хянагдаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд ХАСУМ-ийг (iad.iaac.mn) цахим системээр хүлээн авч хянаж эхэлсэн бөгөөд 2019 онд 1625 мэдүүлгийг тус системийн тусламжтайгаар хүлээн авч хянасан нь нийт мэдүүлгийн 18.7 хувийг эзэлж байна. 8 агентлаг, 5 аймгийн Засаг даргын Тамгын газар, УЕПГ, Улаанбаатар төмөр зам ХНН, Төрийн банк зэрэг 40 байгууллага цахим системд бүрэн холбогдоод байна.

Урьдчилсан мэдүүлгийн 3803 буюу 74.2 хувийг Улаанбаатар хотоос, 1320 буюу 25.8 хувийг орон нутгийн төрийн байгууллагуудаас ирүүлсэн байна.

Хянан шалгасан мэдүүлгээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан 659, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 303 мэдүүлгийг буцааж, 28 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчилтэй байдал тогтоогдож байгааг эрх бүхий албан тушаалтанд мэдэгдсэн байна.

2019 оны тоон үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мэдүүлэг гаргагчдын тоо 1779 нэгжээр буюу 20.9 хувиар, шинээр нийтийн албанд томилогдохоор 1681 нэр дэвшигч байгаа нь 497 нэгжээр буюу 42.0 хувиар буурсан үзүүлэлт болж байна.

Хүснэгт 9 Хянан шалгасан урьдчилсан мэдүүлэг

	Хүлээн авсан	Хянасан	Үүнээс:					Үлдэгдэл
			АСЗ үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй	АСЗ үүсэх нөхцөл байдлыг анхааруулсан	Илт ашиг сонирхлын зөрчил үүсэх	Хуульд зааснаар	Нарийвчлан шалгах	
2018	10461	10378	9060	844	25	439	10	83
2019	8682	8627	7634	659	28	303	3	55

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар албан тушаалд томилогдсон өдрөөс хойш мэдүүлгээ хуулийн хугацаанд гаргаагүй 17, ХАСХОМ-ийн хяналт шалгалтаар хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн 35, ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн 37, нийт 89 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна.


Хүснэгт 10 Хариуцлага тооцуулсан байдал

№	Хариуцлагын төрөл	Шалгалтын төрлөөр			Хариуцлага тооцуулсан албан тушаалтны тоо
		Мэдүүлгийн бүрдүүлэлтийн	ХАСХОМ-ийн	Өргөдөл, гомдлын	
1	Сануулсан	14	6	8	31
2	Цалинг бууруулсан	3	20	22	42
3	Албан тушаал бууруулсан	-	1	4	5
4	Албанаас халсан	-	8	3	11
Дүн		17	35	37	89

Зургаа. Мөрдөн шалгах ажлын талаар

6.1 Тайлант хугацаанд гэмт хэргийн шинжтэй 1137 гомдол, мэдээлэл хүлээн авснаас өмнөх оны үлдэгдэл 8, нийт 894 гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн ба 208 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах бусад байгууллага албан тушаалтанд шилжүүлсэн байна. Энэхүү үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал,


Хүснэгт 1 Шалгаж шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл



Гэмт хэргийн шинжтэй өмнөх оны үлдэгдэл 8, энэ оны 886, нийт 894 гомдол, мэдээллийг салбараар авч үзвэл: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний орлогч, ИТХ-ын 119, аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ-ын 122, УИХ-ын гишүүний 12, УИХ-ын харьяа байгууллагын 7, яамд болон харьяалагдах агентлаг, байгууллагуудын 108, боловсролын 53, цагдаагийн 259, онцгой байдлын 9, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 17, прокурорын 22, шүүхийн 24, банкны 7, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 67, хувийн хэвшлийн ААН, ТББ-ын 39, хилийн цэргийн 1, шүүх шинжилгээний 6, зэвсэгт хүчний 6, эмнэлэгийн 15, Ерөнхийлөгчийн Тамгын газрын 1 гомдол тус тус байна.

Гомдол, мэдээлэлд холбогдсон албан тушаалтныг авч үзвэл: төрийн улс төрийн 141, төрийн захиргааны 204, төрийн тусгай 360, төрийн үйлчилгээний 77, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 71, хувийн хэвшил, аж ахуйн нэгж, болон төрийн бус байгууллагын 41 албан хаагч байна.


Хүснэгт 2 Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэлд холбогдсон албан тушаалтан



2019 оны байдлаар гэмт хэргийн шинжтэй 894 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 4.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүлээн авч шалгасан өмнөх оны 8, шинээр 886, нийт 894 гомдол, мэдээллээс 489 гомдол, мэдээлэл буюу 54.7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, 362 гомдол, мэдээлэл буюу 40.5 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 34 гомдол, мэдээлэл буюу 3.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, 1 гомдол мэдээллийг эрүүгийн хэрэгт хамтатган шалгаж, одоо 8 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 99.1 хувьтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, шийдвэрлэлт 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 3 Гомдол мэдээллийн шийдвэрлэлт



Гомдол, мэдээллийн 564 буюу 63.1 хувийг Улаанбаатар, 330 буюу 36.9 хувийг орон нутгийн харьяаллын гомдол, мэдээлэл эзэлж байна.

6.2 Эрүүгийн хэргийн талаар-Тайлант хугацаанд хуульд заасан харьяаллын 1559 үйлдэлтэй, 481 холбогдогчтой, 1300 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна.

Нийт шалгасан хэргийн 156 буюу 12.0 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 556 буюу 42.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай, 80 буюу 6.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 22 хэргийг нэгтгэн шалгаж, 1 хэргийг түдгэлзүүлж, одоо 485 хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 427 хэрэг, мөрдөн байцаалтын 58 хэрэг байна. Тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн шийдвэрлэлт 62.7 хувьтай, 68 хэрэг буюу 43.6 хувь нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт 4 Хэргийн шийдвэрлэлт
/өнгөрсөн оны мөн үетэй харьцуулсан байдлаар/




Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг Эрүүгийн хуулийн зүйл хэсгээр ангилбал:

- Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/ гэмт хэрэг-688 буюу 44.1 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл /Хахууль авах/ гэмт хэрэг-172 буюу 11.0 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл /Хахууль өгөх/ гэмт хэрэг-174 буюу 11.2 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/ гэмт хэрэг-24 буюу 1.5 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/ гэмт хэрэг-40 буюу 2.6 хувь,
- Эрүүгийн хуулийн 22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ гэмт хэрэг-10 буюу 0.7 хувь,
- Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/ гэмт хэрэг 23 буюу 1.5 хувь,
- Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйл. /Хөрөнгө завших/ гэмт хэрэг-58 буюу 3.7 хувь,
- Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйл. /Эрүү шүүлт тулгах/ гэмт хэрэг-60 буюу 3.9 хувь
- Бусад хэрэг 310 буюу 19.9 хувийг тус тус эзэлж байна.

Хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 48 буюу 9.9 хувийг төрийн улс төрийн, 103 буюу 21.4 хувийг төрийн захиргааны, 101 буюу 21.0 хувийг төрийн тусгай, 48 буюу 9.9 хувийг төрийн үйлчилгээний, 38 буюу 7.9 хувийг төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн албан тушаалтан, 143 буюу 29.7 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн албан тушаалтан, иргэн эзэлж байна.

Хүснэгт 5 Гэмт хэрэгт холбогдон шалгагдсан албан тушаалтан




2019 онд гэмт хэргийн улмаас 12,123,202,011,893 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 11,343,770,066 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж үл хөдлөх,

хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 9,736,776,389,079 төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Учирсан хохирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулвал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 18.3 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 53.9 дахин нэмэгдсэн, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хохирол 35.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлт



---000---